



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Түрээсийн төлбөрийн доод жишиг
үнийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 –ийн "г", 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1, 25.4 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн нэг ам метр талбайн түрээсийн доод жишиг үнийг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

2. Нийслэлийн өмчийн ашиглалт, үр ашгийг дээшлүүлэх, Зохион байгуулалтыг сайжруулах талаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Батболд/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 26 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА




109
ТӨЛӨӨЛӨГЧИЙН

ХУУЛГААР

Хуулбар олгосон ажлын тугаар 109

2018 оны 04 сарын 13 өдөр

САМАРСАЙХАН



**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН
НЭГ МЕТР КВАДРАТ ТАЛБАЙН
ТҮРЭЭСИЙН ЖИШИГ ДООД ҮНЭ**

1. Нийслэлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг бусад хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлэх төлбөрийн доод үнийг түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлийг харгалзан доорх байдлаар тогтооно.

1.1 Түрээсийн төлбөрийн 1м² талбайн доод жишиг үнэ /төгрөг/

№	Түрээслэгчийн эрхэлж буй түрээсийн зориулалт	Нэг метр квадрат талбайн түрээсийн төлбөрийн доод үнэ /төгрөг/
1	Боловсрол соёл шинжлэх ухаан, эрүүл мэндийн үйлчилгээ, сургууль	7.000
2	Бага сургууль, цэцэрлэг	4.500
3	Албан тасалгааны зориулалтаар	10.000
4	Банк, санхүүгийн үйлчилгээ	18.000
5	Нотариат	15.000
6	Худалдаа, үйлчилгээ	9.000
7	Үйлдвэрлэл	8.000
8	Ресторан, баар, караоке, диско клуб, кафе	13.000
9	Цайны газар	10.000
10	Соёлын Төв өргөө, Нийслэлийн Төр захиргааны байрууд /Боловсрол, соёл, шинжлэх ухаан, нийслэлийн төр захиргааны байгууллагуудаас бусад/	16.000
11	Авто худалдааны цогцолборын авто машины зогсоол /Нэг өдрийн/	2.000
12	Бусад	7.000

2. Алслагдсан дүүрэг, хороонд байршилтай эд хөрөнгө, түүнчлэн туслах талбай /Подваль, вестибюль г.м/-г түрээслүүлэхэд түрээсийн төлбөрийн доод үнийг 30 хүртэл хувиар бууруулан тооцож болно.

3. Нийслэлийн өмчийн эд хөрөнгөд өөрийн хөрөнгөөр засвар үйлчилгээ хийн, засан сайжруулж түрээслэх тохиолдолд түрээсийн төлбөрийн жишиг доод үнийг 20 хүртэл хувиар бууруулан тооцож болно.